



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТАТВАРЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 01 сарын 02 өдөр

Дугаар А/01

Арвайхээр

Ээлжийн
амралтын хуваарь
батлах тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйл, Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.6, 61.1.9, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/191 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам, байгууллагын "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 9.12 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус хэлтсийн ажилтнуудын 2024 оны ээлжийн амралтын хуваарийг хавсралтаар баталсугай.

2. Ажилтнуудын ээлжийн амралтын хуваарьт зайлшгүй шаардлагаар өөрчлөлт оруулах тохиолдолд тухай бүр зохицуулалт хийж, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хуулийн тасгийн дарга /А.Ганчимэг/, албан хаагчдын ээлжийн амралтын олговрыг холбогдох журмын дагуу тооцож олгохыг нягтлан бодогч /С.Отгонлхагва/ нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Н.ЭРДЭНЭСУВД

